



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГА Б.НЯМДАВАА ТАНАА

2019.03.25 № 06/588  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Аудитын гол асуудал

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн дараах зөрчлүүдийн дүн бидний тооцсон материаллаг байдлын түвшингээс давсан нь “Хязгаарлалттай санал дүгнэлт” өгөх үндэслэл болно. Үүнд:

- Орон нутаг, нийслэлийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот зарим төслийг “Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөл”-өөр хэлэлцүүлээгүй, тэргүүлэх чиглэл, шалгуур үзүүлэлтийг хангаагүй төсөл хөтөлбөрт 2,115.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон, 33.0 сая төгрөгийн төслийг хэрэгжүүлээгүй, зориулалтын дагуу зарцуулаагүй;
- Орон нутаг, нийслэлийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд олгосон 671.2 сая төгрөгийн зээл, эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийг хугацаанд нь төвлөрүүлээгүй;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд иргэдийг ажлын байраар хангасан Төрийн бус байгууллагуудын 2019 оны үйл ажиллагаанд зориулан 249.6 сая төгрөгийг олгож урьдчилж гарсан зардлаар бүртгэсэн, хөтөлбөр, үйл ажиллагаанд зарцуулсан 150.3 сая төгрөгийн хөрөнгө, зардлыг буруу ангилан бүртгэсэн, 120.2 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй, 28.5 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлээгүй зэрэг нь эрх ба үүрэг, оршин байх, үнэн зөв байдал, иж бүрэн байх, тохиолдсон байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтуудыг тус тус зөрчиж байна.

## Үүрэг хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САНГИЙН 2018 ОНЫ  
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

АУДИТЫН КОД: САГ-2019/13/СТА-ЗГТС

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх  
аудитор Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)  
Аудитын менежер Г.Гүнжидмаа  
Утас: 261885 Цахим хаяг: [gunjidmaag@audit.gov.mn](mailto:gunjidmaag@audit.gov.mn)  
Ахлах аудитор Д.Энхдалай  
Утас: 261628 Цахим хаяг: [enkhdalaid@audit.gov.mn](mailto:enkhdalaid@audit.gov.mn)

Улаанбаатар хот  
2019 он

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## Агуулга

1	Аудитын гэрчилгээ .....	2
2	Аудитын тайлан .....	4
2.1	Оршил.....	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горимсорил, түүний үр дүн.....	8
2.8.1	Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл: .....	8
2.8.2	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар.....	9
2.8.3	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүнгийн талаар.....	9
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	10
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	10
2.11	Шилэн дансны мэдээлэл .....	11
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	11
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
3	Менежментийн захидал.....	13
3.1	Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал .....	13
3.2	Төсөл, хөтөлбөр болон гэрээний биелэлт, хэрэгжилттэй холбоотой асуудал .....	14
4	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..	15
4.1	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан .....	15
4.2	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	16
4.3	Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	17
4.4	Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	18
4.5	Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	19
5	Хавсралт.....	20
5.1	Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийн жагсаалт .....	20

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГА Б.НЯМДАВАА ТАНАА

2019.03.25 № 06/588  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн байна.


### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\Bichig\_Khregl\Yawsan\_Bichig\2019\0325SAG35.Docx



## Аудитын гол асуудал

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн дараах зөрчлүүдийн дүн бидний тооцсон материаллаг байдлын түвшингээс давсан нь "Хязгаарлалттай санал дүгнэлт" өгөх үндэслэл болно. Үүнд:

- Орон нутаг, нийслэлийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот зарим төслийг "Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөл"-өөр хэлэлцүүлээгүй, тэргүүлэх чиглэл, шалгуур үзүүлэлтийг хангаагүй төсөл хөтөлбөрт 2,115.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон, 33.0 сая төгрөгийн төслийг хэрэгжүүлээгүй, зориулалтын дагуу зарцуулаагүй;
- Орон нутаг, нийслэлийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд олгосон 671.2 сая төгрөгийн зээл, эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийг хугацаанд нь төвлөрүүлээгүй;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд иргэдийг ажлын байраар хангасан Төрийн бус байгууллагуудын 2019 оны үйл ажиллагаанд зориулан 249.6 сая төгрөгийг олгож урьдчилж гарсан зардлаар бүртгэсэн, хөтөлбөр, үйл ажиллагаанд зарцуулсан 150.3 сая төгрөгийн хөрөнгө, зардлыг буруу ангилан бүртгэсэн, 120.2 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй, 28.5 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлээгүй зэрэг нь эрх ба үүрэг, оршин байх, үнэн зөв байдал, иж бүрэн байх, тохиолдсон байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтуудыг тус тус зөрчиж байна.

## Үүрэг хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2 Аудитын тайлан

### 2.1 Оршил

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Б.Нямдаваа Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

### 2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 3 дугаар сарын 5-наас 2019 оны 3 дугаар сарын 22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 3 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын ахлах аудитор Д.Энхдалай гүйцэтгэв.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2019 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн 1/259 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

### **2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагааны хүрээнд “Хөдөлмөр эрхлэлт нь иргэн бүр ажил, мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, хувийн аж ахуй эрхлэх эрхийг хангахад чиглэх бөгөөд иргэдийн эдийн засаг, нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулах, орлогын түвшин, амьдралын чанараа дээшлүүлэх үндсэн баталгаа, улс орны хөгжлийн үндэс болно.” гэсэн эрхэм зорилго дэвшүүлэн ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүн амын хөдөлмөрлөх эрхийг хангах боломж, нөхцөлийг бүрдүүлж, ажиллах хүчний мэргэжлийн ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх замаар хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг тэнцвэржүүлэн зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж ядуурлын түвшинг бууруулах.
- Үндэсний хөдөлмөр эрхлэлт, халамжийн үйлчилгээний бодлогын хэрэгжилтийг дэлхийн жишигт хүргэн хөгжүүлэх.
- Нэг цонхны бодлогоор Монгол Улсын иргэдийн дотоод, гадаадын мэргэшсэн хүний нөөцийн зах зээлд гарах гарц нь болох.

- Төрийн үйлчилгээг ил тод, нээлттэй, тэгш шударга, чанартай хүргэх чадварыг байнга дээшлүүлсэн суралцагч байгууллагыг хөгжүүлэх, стратегийн төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын чадамжийг дээшлүүлэх.
- Байгууллагын гадаад, дотоод харилцааг хөгжүүлж салбарын бодлогыг хэрэгжүүлэх, хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх талаар хамтран ажиллах, төр, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх.
- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний цахим мэдээллийн нэгдсэн сүлжээг боловсронгуй болгож, төрийн зохих байгууллагуудын сүлжээ, мэдээлэлтэй нэгдмэл байдлыг хангах.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн удирдлага төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
- Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай
- Нийгмийн халамжийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

## **2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд аудитад мэдээллийн технологийн мэргэжилтэн татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн нэгтгэсэн тайланг “Гөү Окей” ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн “Axplorer”, санхүүгийн нэгтгэсэн тайланг “Талст 1.03” програм хангамжуудыг ашиглан бэлтгэдэг байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хяналт мониторингийн газар нь 2018 онд 4 аймаг 3 дүүргийн эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийжээ. Хөвсгөл, Хэнтий, Сүхбаатар, Өмнөговь аймгийн ХХҮГ, Багахангай, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүргийн ХХҮХ-ийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 2017 онд хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрүүдийн эргэн төлөлт хуваарийн дагуу төлөгдөхгүй тус сангийн бүрдүүлэлт 40 гаруй хувьтай байна гэж дүгнэж, гарсан нийтлэг зөрчлүүдийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах талаар зөвлөмж чиглэл өгч ажиллажээ.

## **2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 10 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 10 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б 401, Б 402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн нийт хөрөнгийг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшинг сонгосон суурь үзүүлэлтийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2017 оны нэгтгэсэн

санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгө болох 112,079.7 сая төгрөгийн 1 хувиар тооцон, урьдчилсан байдлаар 1,120.8 сая төгрөгөөр тогтоосон.

Аудитын гүйцэтгэлийн шатанд 2018 оны санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн нийт хөрөнгө болох 145,056.1 сая төгрөгийн 1 хувиар тооцон, материаллаг байдлын түвшинг 1,450.6 сая төгрөгөөр тогтоолоо.

Байгууллагын үйл ажиллагаа, санхүүгийн нэгтгэсэн тайлан, балансын дансанд хийсэн эрсдэлийн үнэлгээг үндэслэн материаллаг байдлын түвшинг суурь үзүүлэлтээс 1 хувиар тооцсон.

## 2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горимсорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд эрхлэх асуудлын хүрээний 33 байгууллага, нэгжийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

№	Байгууллагын ангилал	Санал дүгнэлт гаргасан	Аудитын түүвэрт хамрагдсан	Итгэл үзүүлсэн	Аудитад хамрагдаагүй
1	Төсвийн шууд захирагч	32	1	0	0
	<b>Дүн</b>	<b>32</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>0</b>

Аудитаар 21 санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, 10 санхүүгийн тайланд “Хязгаарлалттай”, 1 санхүүгийн тайланд “Сөрөг” санал дүгнэлт гаргасан байна.

### 2.8.1 Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 6,594.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 15.8 хувь буюу 999.8 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 0.4 хувь буюу 26.7 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 20.4 хувь буюу 1,343.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага өгч, 64.1 хувь буюу 4,224.2 сая төгрөгийн зөрчлийг засах, давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүлээ.

Аудитаар төсвийн шууд захирагчийн хэмжээнд 999.8 сая төгрөгийн алдааг залруулсан болно.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчил түүний шийдвэрлэлтийг дараах хүснэгтээр нэгтгэн үзүүлэв.

(сая төгрөг)

№	Байгууллагын ангилал	Залруулаагүй алдаа, зөрчил		Үүнээс:							
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах санал	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ТШЗ	53	5,325.4	7	26.7	10	1,343.6	36	3,955.1	0	0
2	ТТЗ	2	269.2	0	0	0	0	2	269.2	0	0
	Дүн	55	5,594.6	7	26.7	10	1,343.6	38	4,224.3	0	0

### 2.8.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн харьяа дэд сангуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар Говь-Алтай, Хөвсгөл аймаг, Багахангай, Баянгол, Сонгинхайрхан, Сүхбаатар, Налайх, Хан-Уул, Чингэлтэй дүүрэг, Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн тайланд “Хязгаарлалттай”, Баянзүрх дүүргийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн тайланд “Сөрөг” санал дүгнэлт гаргасан.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн харьяа дэд сангуудын 2018 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 6,325.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 999.8 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 26.7 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1,343.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага өгч, 3,955.1 сая төгрөгийн зөрчлийг засах, давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүлээ.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах нийтлэг зөрчил илэрлээ. Тухайлбал:

- Хөтөлбөр, үйл ажиллагаанд зарцуулсан 150.3 сая төгрөгийн хөрөнгө, зардлыг буруу ангилан бүртгэсэн, 120.2 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй, 28.5 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлээгүй.
- Орон нутаг, нийслэлийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төслийг Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлөөр хэлэлцүүлээгүй, тэргүүлэх чиглэл, шалгуур үзүүлэлтийг хангаагүй төсөл хөтөлбөрт 2,115.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон, 33.0 сая төгрөгийн төслийг хэрэгжүүлээгүй, зориулалтын дагуу зарцуулаагүй, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд олгосон 671.2 сая төгрөгийн зээл, эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийг хугацаанд нь төвлөрүүлээгүй зэрэг зөрчил илэрлээ.

### 2.8.3 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүнгийн талаар

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлсэн горим сорилын гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр 10 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 2 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 8 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэлээ.

Аудитаар илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн тайланд илэрсэн 2 асуудалд зөвлөмж өгч менежментийн захидалд тусгасан, бусад хэлбэрээр шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

## **2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн тайланд 2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар нийт 22,469.9 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээл, эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгийн үлдэгдэл бүртгэлтэй байна. Тухайлбал:

- Оёдлын нэгдсэн холбоонд “Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжих” хөтөлбөрийн хүрээнд 2013 онд дамжуулан зээлдүүлэх гэрээгээр олгосон зээлээс 15,819.9 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийн үлдэгдэл барагдаагүй зээлийн барагдуулахаар тухайн үед зээлийг хариуцаж олгосон Хүнс, хөдөө аж, ахуйн яам шүүхэд нэхэмжлэл гаргасан байна.
- Жижиг зээлийг санхүүжүүлэхээр Капитал банкинд 2016 онд олгосон зээлээс 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 6,650.0 сая төгрөг барагдаагүй байсан. Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газраас 2018 онд хийсэн аудитаар төлбөрийн акт тогтоосон. 2019 оны 3 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар жижиг зээлийн үлдэгдлээс 5,350.0 сая төгрөгийг барагдуулж 1,300.0 сая төгрөг үлдэгдэлтэй байна.

## **2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн төвлөрүүлэн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд 6 хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхэд зориулан 65,348.0 сая төгрөгийн төсөв зарцуулах, үүний 3,850.0 сая төгрөгийг улсын төсвөөс, 48,384.0 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос, 2,114.0 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс, 11,000.0 сая төгрөгийг дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх эх үүсвэрээс санхүүжүүлэхээр батлагджээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Орлогын гүйцэтгэлийг авч үзвэл улсын төсвөөс 3,850.0 сая төгрөгийн санхүүжилт авч, 47,352.9 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос, 39,244.0 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс, 4,450.0 сая төгрөгийг дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх эх үүсвэр болон орон нутгийн нөөц сангаас, 3,137.8 сая төгрөгийг гадаад эх үүсвэрээс нийт 98,034.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж ажиллажээ.

Зардлын нийт гүйцэтгэл 50,673.3 сая төгрөг буюу 77.5 хувьтай байгаа нь эргэн төлөгдөх зээлд 7,000.0 сая, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшууллын зардлыг 7,655.2 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжид 19.5 сая төгрөгийг тус тус дутуу зарцуулснаас шалтгаалжээ. Оны эцэст зарцуулагдаагүй үлдэгдэл 47,261.4 сая төгрөгийг Сангийн яаманд төвлөрүүлсэн байна.

### **2.11 Шилэн дансны мэдээлэл**

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүргийн дагуу 2018 оны төсөв, гүйцэтгэл, 5000.0 мянган төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээг тухай бүр нь цахим хуудсанд мэдээллэсэн байна.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

### **2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 4 зөвлөмж өгснөөс 3 зөвлөмжийг хэрэгжүүлж, 1 зөвлөмж хэрэгжээгүй буюу нийт 75 хувийн биелэлттэй байна. Үүнд:

- Тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй татан буугдсан Анод банк болон Дэлгэр экспресс ББСБ-аас авах 847.5 сая төгрөг авлага эргэн төлөгдөх найдваргүй байна. Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албан хандсан боловч шийдвэрлэгдээгүй байна.

Зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримтаар баталгаажуулж, гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хэмжээнд танилцуулга хийсэн болно.

### **2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдаагүй алдаа зөрчлийг эс тооцвол 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн

гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна. “Хязгаарлалттай санал дүгнэлт” өгөх үндэслэлийг Аудитын гэрчилгээний аудитын гол асуудал хэсэгт тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### 3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### 3.1 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

##### 3.1.1 Илрүүлэлт:

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 2018 оны 12 дугаар сарын 21-ын өдөр Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дарга нар хамтарсан А/283, А/25 дугаартай тушаалаар 2018 оны 12 дугаар сарын 24-өөс 2019 оны 6 дугаар сарын 25-ны хүртэл Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангах 25 төрийн бус байгууллагад санхүүгийн дэмжлэг олгох гэрээг байгуулан 249.6 сая төгрөгийн санхүүжилтийг олгон, урьдчилж гарсан зардлаар бүртгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8. дахь "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.", 43 дугаар зүйлийн 43.5. дахь "Төсвийн захирагч нь ... төсвийг хоёр төсвийн жил дамжуулан зарцуулахгүй." заалтыг зөрчсөн.

3.1.2 Эрсдэл: Холбогдох хууль, журам, зааврыг хэрэгжүүлээгүй байх;

3.1.3 Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль, журам, зааврыг хэрэгжүүлж ажиллах, төсвийг зохистой удирдаж өр, авлага үүсгэхгүй байх;

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

### **3.2 Төсөл, хөтөлбөр болон гэрээний биелэлт, хэрэгжилттэй холбоотой асуудал**

#### **3.2.1 Илрүүлэлт:**

Орон нутаг, нийслэлийн онцлог, хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төслийн санхүүжилтээр 29 аж ахуйн нэгж, иргэнд 2017 онд олгосон 3,986.0 сая санхүүгийн дэмжлэгээс гэрээний дагуу 336.1 сая төгрөгийг буцаан төвлөрүүлэхээс 10 аж ахуйн нэгж, иргэн дутуу, 8 нь огт төлөлт хийгээгүй нийт 19.5 сая төгрөгийг буцааж төвлөрүүлээгүй, 5 төслийн хэрэгжилтийн явцын талаар тайлан, мэдээ ирүүлээгүй байна.

3.2.2 Эрсдэл: Тухайн байгууллага гэрээ, хэлэлцээрийн дагуу ямар нэгэн үүрэг хариуцлага хүлээдэг боловч, түүнийг төлөөгүй, бүртгэлд тайланд тусгаагүй байх;

3.2.3 Өгсөн зөвлөмж: Гэрээний үүргийн хэрэгжилтийг хангуулах талаар анхаарч ажиллах;

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2019 оны 9 дүгээр сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	112,079,670.9	145,068,112.5
33	АВЛАГА	111,625,640.9	144,809,678.5
335	Бусад авлага	3,981,546.9	4,117,004.8
336	Зээлийн авлага	68,400,091.1	93,431,040.1
3361	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	68,400,091.1	93,431,040.1
34	УРЬДЧИЛГАА	454,030.0	258,434.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	112,079,670.9	145,068,112.5
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	269,973.4	18,593,326.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	269,973.4	18,593,326.0
412	Богино хугацаат зээлийн өглөг	33,795.9	10,250.9
413	Өглөг	236,177.5	48,391.3
4136	Бусад өглөг	235,149.6	47,363.4
414	Урьдчилж орсон орлого	-	18,534,683.8
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	111,809,697.5	126,474,786.4
51	Засгийн газрын хувь оролцоо	111,809,697.5	126,474,786.4
512	Хуримтлагдсан үр дүн	111,809,697.5	126,474,786.4
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	112,079,670.9	145,068,112.5

#### 4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	32,401,815.7	28,984,534.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	32,097,815.7	25,034,534.1
120	Нийтлэг татварын бус орлого	32,097,815.7	25,034,534.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	304,000.0	3,950,000.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	3,850,000.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	304,000.0	100,000.0
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	13,782,318.5	14,046,133.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	13,782,318.5	14,046,133.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	150,269.4	175,800.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	150,269.4	175,800.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,632,049.1	13,870,332.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,632,049.1	13,870,332.8
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	18,619,497.2	14,938,401.1
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	18,619,497.2	14,938,401.1

### 4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	93,883,261.7	98,034,737.1
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	93,579,261.7	89,734,737.1
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	93,579,261.7	89,734,737.1
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	304,000.0	8,300,000.0
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	-	8,200,000.0
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	304,000.0	100,000.0
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	73,883,266.8	82,134,737.1
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	73,883,266.8	82,134,737.1
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	157,232.4	178,488.2
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	157,232.4	178,488.2
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	73,726,034.4	81,956,249.0
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	34,482,031.4	34,694,839.4
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	39,244,002.9	47,261,409.6
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	19,999,994.9	15,900,000.0
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	20,000,000.0	15,900,000.0
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	(20,000,000.0)	(15,900,000.0)
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	(5.2)	-
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	5.2	-
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		

#### 4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
<b>2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	94,582,925.2	-	94,582,925.2
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(1,392,724.9)	-	(1,392,724.9)
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	93,190,200.3	-	93,190,200.3
Тайлант үеийн үр дүн	18,619,497.2	-	18,619,497.2
<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	111,809,697.5	-	111,809,697.5
<b>2018 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	111,809,697.5	-	111,809,697.5
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(273,312.2)	-	(273,312.2)
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	111,536,385.3	-	111,536,385.3
Тайлант үеийн үр дүн	14,938,401.1	-	14,938,401.1
<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	126,474,786.4	-	126,474,786.4

#### 4.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	65,348,000.0	50,673,327.6	14,674,672.4	77.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	42,448,000.0	34,773,327.6	7,674,672.4	81.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	198,000.0	178,488.2	19,511.8	90.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	198,000.0	178,488.2	19,511.8	90.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	198,000.0	178,488.2	19,511.8	90.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	42,250,000.0	34,594,839.4	7,655,160.6	81.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	42,250,000.0	34,594,839.4	7,655,160.6	81.9
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	42,250,000.0	34,594,839.4	7,655,160.6	81.9
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	22,900,000.0	15,900,000.0	7,000,000.0	69.4
230001	Эргэж төлөгдөх зээл	22,900,000.0	15,900,000.0	7,000,000.0	69.4
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	65,348,000.0	94,786,622.0	(29,438,622.0)	145.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,850,000.0	3,850,000.0	-	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,850,000.0	3,850,000.0	-	100.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	50,498,000.0	86,586,622.0	(36,088,622.0)	171.5
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	48,384,000.0	47,342,619.1	1,041,380.9	97.8
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	2,114,000.0	39,244,002.9	(37,130,002.9)	1,856.4
14	БУСАД ЭХ ҮҮСВЭР	11,000,000.0	4,350,000.0	6,650,000.0	39.5
145005	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	11,000,000.0	4,350,000.0	6,650,000.0	39.5

## 5 Хавсралт

### 5.1 Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийн жагсаалт

<b>Огноо:</b> 2019/3/22	<b>Аудитын нэр:</b>	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудит	<b>Аудитын код:</b>	САГ-2019/13/СТ А-ЗГТС
<b>Шалгагдсан байгууллагын нэр:</b>	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан			<b>сая төгрөгөөр</b>

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл			Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Огноо	Дугаар	Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5	6	7
1	Орон нутаг, нийслэлийн онцлог, хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төслийн санхүүжилтээр 2017 онд олгосон санхүүгийн дэмжлэгээс буцаан төлөх 19.5 сая төгрөгийг төвлөрүүлээгүй.	19.5	Зөвлөмж			Дарга: Ерөнхий нягтлан бодогч:	Б.Нямдаваа, Б.Оюунбилэг
2	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд гэрээ байгуулан 25 төрийн бус байгууллагад 249.6 сая төгрөгөөр төлөвлөгдөөгүй арга хэмжээг санхүүжүүлэн, урьдчилж гарсан зардлаар бүртгэсэн	249.6	Зөвлөмж			Дарга: Ерөнхий нягтлан бодогч:	Б.Нямдаваа, Б.Оюунбилэг
	Нийт	269.1					

Утас: +976 51 261585

Факс: +976 11 323266, 324653

Цахим шуудан: [info@audit.gov.mn](mailto:info@audit.gov.mn)

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Хаяг: Засгийн газрын IV байр  
Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг  
Улаанбаатар-15160, Монгол Улс